



2026 он 05 сар 15 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

**Азийн Хөгжлийн Банкнаас зээл авах,
гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.18 дахь заалт болон Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.14, 6.2.7.17 дахь заалтуудыг удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-аас эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор 3 (гурван) жилийн хугацаатай 20,000,000 (хорин сая) ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийг авах, холбогдох зээлийг гэрээг АХБ-тай байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан хөрөнгийг АХБ-аас авах зээлийн үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож барьцаалуулах, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх бол өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх, мөн дараах барьцааны гэрээнүүдийг байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д олгосугай. Үүнд: (i) үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (газар), (ii) үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (барилга), (iii) хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, (iv) (АХБ-аас нэмж шаардах тохиолдолд) хувьцааны барьцааны гэрээ.
3. Энэхүү тогтоолын 1, 2 дахь хэсэгт дурдсан заасан зээлийн гэрээний нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцож, улмаар Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ